

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь “Баяжуулах үйлдвэрийн шинэ хаягдал хураах сангийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” төслийг хэрэгжүүлэх зорилгоор ажил үйлчилгээний гэрээ байгуулахаар сонирхогч этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь 1978 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 40 сая тонн хүдэр боловсруулж 600.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 6.3 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.
Үйлдвэрийн тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах үүднээс хөвүүлэн баяжуулах технологийн хаягдлыг хураах шинэ санг ойрын ирээдүйд байгуулахаар төлөвлөж байна. Энэ төслийн техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн боловсруулах ажлыг гүйцэтгэх техникийн болон үнийн саналыг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 14:00 цагаас өмнө investdepartment@erdenetmc.mn цахим хаягаар үнийн санал ирүүлэхийг урьж байна.
Шинэ хаягдлын сангийн үйл ажиллагаа, аюулгүй байдал нь олон улсын стандартад нийцсэн байх шаардлагатай ба хийгдэх ажлын ерөнхий цар хүрээг хавсралтаар хүргүүлж байна. Та бүхэнд төслийн талаар нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол бидэнтэй доорх хаягаар холбогдоно уу. (eprocurement@erdenetmc.mn, enkhhchuluun.d@erdenetmc.mn)
3. Хуулийн этгээд нь доорх үндсэн шаардлагуудын хангасан байна. Үүнд:
 - 2020, 2021, 2022 оны санхүүгийн тайлант аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.
 - Хуулийн этгээд нь татварын өр төлбөргүй тухай үүсгэн байгуулагдсан улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ
 - Сүүлийн 10 жилийн (2012-2022 онуудад) хугацаанд хийж гүцэтгэсэн ижилт төстэй ажлын жагсаалт, эдгээр төслүүд нь амжилттай хэрэгжиж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа тухай захиалагчийн тодорхойлолт бичгийн хамт ирүүлнэ.
Ижилт төстэй ажилд: Баяжуулах үйлдвэрийн /жилд 40 сая тонноос багагүй хаягдал хураадаг/ хаягдлын далангийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж байсан ажлыг тооцох ба энд зааснаас өөр ангилалд хамаарах зөвлөх үйлчилгээг ижилт төстэйд тооцохгүй.
4. Ажлын төсөв: 5,850,000,000 төгрөг.
5. Энэхүү туршлагад тооцуулах гэрээний нийт үнэ нь захиалагчийн санал болгож буй төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.
6. Сүүлийн 3 жилийн (2020, 2021, 2022 онуудын) борлуулалтын орлогын нийлбэр нь санал болгож буй төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.
7. Боловсон хүчний талаарх доорх мэдээллүүдийг ирүүлнэ. Үүнд:
 - Төслийн удирдагч: Хаягдлын менежмент, далангийн зураг төсөл ашиглалтын чиглэлээр 20-оос доошгүй жил ажилласан туршлагатай. Хаягдлын далангийн зураг төсөл, барьж байгуулах ажилд төслийн удирдагчаар ажиллаж байсан туршлагатай.
 - Геотехникийн мэргэжилтэн: Хаягдлын далангийн тогтвортой байдлын тооцоолол, дизайны чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай.

- Барилгын инженер: Далангийн барилга байгууламж, зураг төслийн чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
 - Шингэн тээврийн мэргэжилтэн: Хаягдал булинга тээвэрлэлт, шугам хоолойн тооцоо, зураг төсөл боловсруулах чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
 - Усны менежментийн мэргэжилтэн: Хаягдлын ус ашиглалт, гидравлик системийн тооцоо, зураг төсөл боловсруулах чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
 - Байгаль орчны мэргэжилтэн: Хаягдлын далангийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эдгээрийн бууруулах далангийн дизайн, арга аргачлал боловсруулах чиглэлээр 10-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай.
 - Цахилгааны инженер: Уул уурхайн цахилгаан хангамж, дэд бүтцийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай.
 - Механик инженер: Уул уурхайн салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай.
8. Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлэх.
 9. Зөвлөх нь ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор түншлэх буюу эсвэл туслан гүйцэтгэгчтэй хамтарч болно.
 10. Дотоодын давуу эрх олгох эсэх: Үгүй.
 11. Холбогдох баримт бичгүүдийг Англи эсвэл Монгол хэл дээр ирүүлнэ.